





ЗАМ ТЭЭВЭР

2024



СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ



СУДАЛГАА, СТАНДАРТ,
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
2025 ОН

АГУУЛГА

ДҮГНЭЛТ 5

БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ 7

 Ачаа тээвэр 7

 Зорчигч тээвэр 13

БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР 16

БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР 18

 Зорчигч тээвэр 18

 Ачаа тээвэр 19

 Тээврийн хэрэгслийн бүртгэл 22

БҮЛЭГ 4. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР 25

 Зорчигч тээвэр 26

 Ачаа тээвэр 27

 Галт тэрэг солилцоо 31

 Хөдлөх бүрэлдэхүүн 32

 Төмөр замын сүлжээ 33

БҮЛЭГ 5. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР 35

 Зорчигч тээвэр 35

 Ачаа тээвэр 38

 Нислэг гүйцэтгэл 39

БҮЛЭГ 6. ДАЛАЙН ТЭЭВЭР УСАН ЗАМЫН САЛБАР 40

 Зорчигч тээвэр 40

 Тээврийн хэрэгслийн бүртгэл 40

 Монгол улсын далбаатай хөлөг онгоцны бүртгэл 41

ХАВСРАЛТ 43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Нийт тээсэн ачаа	7
Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт.....	8
Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин.....	8
Зураг 4 Ачаа эргэлт, сая тонн.км.....	8
Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар.....	9
Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт.....	9
Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр	10
Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	10
Зураг 9 Тээвэрлэлтийн төрөл, салбараар.....	11
Зураг 10 Улс хоорондын ачаа тээвэр	11
Зураг 11 Ачаа гаргалт (экспорт).....	12
Зураг 12 Ачаа оруулалт (импорт).....	12
Зураг 13 Төмөр замын дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин	12
Зураг 14 Зорчигч тээвэр	13
Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт.....	14
Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь.....	14
Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр	14
Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр.....	15
Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км.....	15
Зураг 20 Улсын чанартай авто зам	16
Зураг 21 Орон нутгийн чанартай авто зам	16
Зураг 22 Тусгай зориулалтын авто зам	16
Зураг 23 Улсын чанартай авто замын гүүр.....	16
Зураг 24 Улсын чанартай авто замын сүлжээ	17
Зураг 25 Автотээврийн зорчигч, сая хүн.....	18
Зураг 26 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр	18
Зураг 27 Автотээврийн зорчигч эргэлт	18
Зураг 28 Автотээврийн экспортын ачаа	19
Зураг 29 Экспортын ачаа, эзлэх хувь	20
Зураг 30 Автотээврийн импортын ачаа	20
Зураг 31 Боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгсэл, эзлэх хувь.....	21
Зураг 32 Тээврийн хэрэгслийн ангилал.....	22
Зураг 33 Жолооны хүрдний байрлал	22
Зураг 34 Хөдөлгүүрийн багтаамж	22
Зураг 35 Тээврийн хэрэгслийн импорт – улсаар, тээврийн хэрэгслийн төрлөөр.....	23
Зураг 36 Автомашины насжилт	23
Зураг 37 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл	25
Зураг 38 Төмөр замын зорчигч эргэлт.....	26
Зураг 39 Төмөр замын ачаа эргэлт.....	27
Зураг 40 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь.....	28
Зураг 41 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин.....	28
Зураг 42 Төмөр замын улс хоорондын ачаа тээвэр, эзлэх хувь.....	28
Зураг 43 Төмөр замын экспортын тээврийн хэмжээ, эзлэх хувь.....	29
Зураг 44 Төмөр замын импортын тээврийн хэмжээ, эзлэх хувь	29
Зураг 45 Төмөр замаар дамжин өнгөрсөн ачаа тээврийн хэмжээ, эзлэх хувь	29
Зураг 46 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх хувь	29
Зураг 47 Төмөр замаар тээсэн ачааны төрөл.....	30
Зураг 48 Төмөр замаар тээсэн ачааны өөрчлөлт	30
Зураг 49 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл.....	30

Зураг 50 Хүлээн авсан вагон	31
Зураг 51 Хүлээлгэн өгсөн вагон	31
Зураг 52 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл	32
Зураг 53 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч	32
Зураг 54 Төмөр замын сүлжээний урт	33
Зураг 55 Суурь бүтэц эзэмшигч	33
Зураг 56 Монгол Улсын үндэсний төмөр замын сүлжээ	34
Зураг 57 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь	35
Зураг 58 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд	35
Зураг 59 Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр	36
Зураг 60 Олон улсын зорчигч, чиглэлээр	36
Зураг 61 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр	36
Зураг 62 Орон нутгийн зорчигч, чиглэлээр	37
Зураг 63 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр	37
Зураг 64 Ачаа, шуудангийн эзлэх хувь	38
Зураг 65 Ачаа тээврийн үзүүлэлт	38
Зураг 66 Нислэгийн үзүүлэлт	39
Зураг 67 Салбарын орлогын үзүүлэлт	39
Зураг 68 Усан замын зорчигч тээвэр	40
Зураг 69 Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл	40
Зураг 70 Усан замын тээврийн хэрэгсэл, аймгаар	40
Зураг 71 Техник хяналтын үзлэгийн дүн	41
Зураг 72 Бүртгэлтэй хөлөг онгоцны тоо	41
Зураг 73 Далайд тээсэн ачааны нэр төрөл	42

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

Хянасан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа

Боловсруулсан:

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Нэмэхжаргал

Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхзаяа

Энэхүү эмхэтгэлийг УСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

ДҮГНЭЛТ

Зам, тээврийн яамнаас тээвэр зохион байгуулалтын шуурхай, найдвартай байдлыг хангах, бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого зорилт дэвшүүлж ажилласны үр дүнд ачаа болон зорчигч тээврийн хэмжээ нэмэгдлээ.

Ачаа тээвэр

Зам, тээврийн салбар 2024 онд бүх төрлийн тээврээр нийт 131.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 22.1%-аар өслөө. Мөн ачаа эргэлт 2023 онд 29,512.7 сая тн.км байсан бол 2024 онд 33,992.8 сая тн.км болж 15.2%-аар өслөө.

Нийт ачаа тээврийн 64.9%-ийг автотээвэр, 35.0%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Автотээврийн ачаа 85.2 сая тонн болж өмнөх оноос 19.5%-аар, төмөр замын тээврийн ачаа 45.9 сая тонн болж өмнөх оноос 27.1%-аар, агаарын тээврийн ачаа 10.4 мянган тонн болж өмнөх оноос 21.2%-аар тус тус өссөн байна.

2024 онд тээвэрлэсэн нийт ачааны 90.5% буюу 118.6 сая тонн нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 5.1 сая тонн буюу 3.9% нь барилгын салбарын бүтээгдэхүүн, 1.5 сая тонн буюу 1.1% нь хүнс хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 5.9 сая тонн буюу 4.5% нь бусад салбарын ачаа байна.

Үүнээс автотээврээр тээвэрлэсэн ачааны 96.2%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 80.0% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

2023 онд улс хоорондын ачаа тээвэр 86.0 сая тонн болж нийт ачаа тээврийн 80.1%-ийг эзэлж байсан бол 2024 онд 100.6 сая тонн болж нийт ачаа тээврийн 76.7%-ийг эзэлж байна.

Үүнээс экспортын ачаа нийт ачаа тээврийн 71.5%-ийг эзэлж байгаа бөгөөд 2024 онд 93.7 сая тонн болж өмнөх оноос 18.0%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин импортын ачаа 6.9 сая тонн болж өмнөх оноос 3.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн 2024 онд дотоодын ачаа 25.2 сая тонн болж өмнөх оноос 54.9%, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.3 сая тонн болж өмнөх оноос 4%-аар тус тус өсжээ.

2024 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.5% нь БНХАУ-тай, 3.5% нь ОХУ-тай хиллэж буй боомтоор орж, гарсан байна. БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 96.3% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 92.8% нь импортын ачаа байна.

Монгол улсын далбаатай хөлөг онгоцоор 2023 онд нийт 268,231.28 MTS буюу 295,647.61 тонн ачаа тээвэрлэсэн. 2024 оны хагас жилийн байдлаар нийт 125,751.768 MTS буюу 138,678.401 тонн ачаа тээвэрлэсэн бол 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 3,320,420.54 MTS буюу 3,660,140.11 тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 11 дахин өссөн байна.

Зорчигч тээвэр

2024 онд бүх төрлийн тээврээр нийт 149.4 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.0%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 142.8 сая байна.

Бүх төрлийн тээврээр олон улс болон орон нутагт зорчигчдын тоо 2024 онд 6.6 сая болж өмнөх оноос 6.0%-аар өслөө. Үүнээс агаарын тээврээр 2.2 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 25.2%, усан замаар 94.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 45.7%, автотээврээр 2.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 3.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 2.0 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 7.7%-аар буурчээ.

2024 онд олон улсын зорчигч тээвэрлэлт өмнөх оноос 17.0%-аар өсч, 2.6 сая боллоо.

Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 1.7 сая болж өмнөх оноос 33.1%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 68.3%-ийг эзэлж байна. Харин олон улсад төмөр замаар зорчигчийн тоо 73.8%-аар нэмэгдэж 41.2 мянга болсон байна.

Тээврийн дэд бүтэц*Авто зам*

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,960.1 км авто зам, орон нутгийн чанартай 95,990.6 км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам байна.

2024 онд нийт 567.1 км хатуу хучилттай авто зам, 208.9 урт метр гүүр шинээр ашиглалтад орууллаа. Ингэснээр олон улс, улсын чанартай 7,887.8 км, орон нутгийн чанартай 1,976.7 км, тусгай зориулалтын 966.0 км, нийт 10,830.5 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

2024 оны байдлаар 21 аймаг, 107 сум хатуу хучилттай авто замтай болоод байна.

Төмөр зам

Сүүлийн 4 жилийн хугацаанд төмөр замын сүлжээний гол замын уртыг 935.1 км-ээр, салбар замын уртыг 204.2 км-ээр, нийт уртыг 1,139.3 км-ээр нэмэгдүүлжээ.

Ингэснээр Монгол Улсын төмөр замын сүлжээний нийт урт 3,368.8 км болсон бөгөөд үүнээс гол төмөр замын урт 2,420.1 км, салбар төмөр замын урт 948.7 км байна.

Тээврийн хэрэгсэл*Автотээвэр*

2024 оны жилийн эцсийн байдлаар 1,338,956 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 146,436 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн буюу 12.3%-аар өссөн байна.

Улаанбаатар хотод 796,681 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 59.4%-ийг, орон нутагт 542,275 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 40.6%-ийг эзэлж байна.

2024 онд автотээврийн хэрэгслийн техник хяналтын үзлэгт нийт тээврийн хэрэгслийн 74.9% хамрагдсан нь өмнөх оноос 2.7%-аар өссөн үзүүлэлт байна.

Хөдлөх бүрэлдэхүүн

Төмөр замын салбарт 2024 оны жилийн эцсийн байдлаар хөдлөх бүрэлдэхүүний нийт тоо 11,786 байгаагаас хагас вагон 7,163 тавцант вагон 1,996, зорчигчийн вагон 321, зүтгүүр 208, машин механизм 83, бусад 2,015 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна.

Агаарын хөлөг

2024 оны байдлаар Монгол улсад нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй 31 агаарын хөлөг бүртгэлтэй байгаагаас зорчигч тээврийн 17 агаарын хөлөг бүртгэлтэй байна.

Усан замын тээврийн хэрэгсэл

Монгол Улсад дотоодын усан замын 233 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 27 буюу 13.1%-аар өссөн байна. 2024 онд 146 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нь өмнөх онтой адил байна.

Бусад үзүүлэлт

Монгол Улсад 2024 оны байдлаар автотээврийн хэрэгслийн 93,049 мэргэшсэн жолооч бүртгэгдсэн нь өмнөх оноос 6.6%-аар өссөн байна. Нийт мэргэшсэн жолоочийн 1.4% буюу 1,316 эмэгтэй мэргэшсэн жолооч бүртгэлтэй байна.

Зам, тээврийн салбарын иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлдэг үйлчилгээний тоо 94 байгаагаас 92 үйлчилгээ нь цахимжсан байна.

Тус салбарын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол нийтдээ 41 болсноос төмөр замын салбарт 16, иргэний нисэхийн салбарт 24 тохиолдол гарсан байна.


БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2024 ОНД АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ **131.1 САЯ ТОНН** БОЛЖ ТҮҮХЭН АМЖИЛТ ТОГТООЛОО.

Ачаа тээвэр


Бүх төрлийн тээврээр 2024 онд нийт 131.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 22.1%-аар өслөө. Үүнээс автотээврийн ачаа 85.2 сая тонн болж өмнөх оноос 19.5%, төмөр замын тээврийн ачаа 45.9 сая тонн болж өмнөх оноос 27.1%, агаарын тээврийн ачаа 10.4 мянган тонн болж өмнөх оноос 21.2%-аар тус тус өссөн байна.

Нийт ачаа эргэлт 2023 онд 29,512.7 сая тн.км байсан бол 2024 онд 33,992.8 сая тн.км болж 15.2%-аар өслөө.




Тээврийн төрөл	2019	2020	2021	2022	2023	2024
Нийт тээсэн ачаа, мянган тонн	68,997.5	60,297.8	49,238.1	60,813.4	107,377.6	131,075.0
Төмөр зам	28,143.0	29,840.1	31,261.4	27,724.9	36,114.1	45,899.1
Автотээвэр	40,848.8	30,455.0	17,970.3	33,075.6	71,254.9	85,165.5
Агаарын тээвэр	5.8	2.7	6.4	12.9	8.6	10.4
Нийт ачаа эргэлт, сая тн.км	23,601.8	23,861.0	20,674.6	17,534.1	29,512.7	33,992.8
Төмөр зам	17,384.1	19,167.6	18,345.1	14,910.2	18,869.3	21,217.6
Автотээвэр	6,203.8	4,685.3	2,313.9	2,591.9	10,619.1	12,746.1
Агаарын тээвэр	13.9	8.1	15.6	32.0	24.3	29.0

Зураг 1 Нийт тээсэн ачаа




2024 онд бүх төрлийн тээврээр тээсэн нийт ачаа болон авто тээвэр, төмөр замаар тээсэн ачааны хэмжээ тус тус түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн бөгөөд 2019-2022 оны жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулбал, нийт тээсэн ачаа 88.9%, автотээврийн ачаа 2.2 дахин, төмөр замын тээврийн ачаа 49.8%-аар тус тус илүү байна.

Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт




2023 онд нийт ачаа тээврийн дүнд 66.36%-ийг автотээвэр, 33.63%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа тус тус эзэлж байсан бол 2024 онд 64.9%-ийг автотээвэр, 35%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээвэр эзэлж байна.

Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин



Зураг 4 Ачаа эргэлт, сая тонн.км



2024 онд нийт ачаа эргэлт 33,992.8 сая тн.км болж 2019 оны түвшингээс 44.0%-аар өссөн бол өмнөх оноос 15.2%-аар өсжээ.

Автотээврийн ачаа эргэлт 2024 онд 12,746.1 сая тн.км болж өмнөх оноос 20%-аар, 2019 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Нийт ачаа эргэлтэд төмөр замын ачаа эргэлт хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. 2024 онд 21,217.6 сая тн.км болж өмнөх оноос 12.4%, 2019 оны түвшингээс 22.1%-аар өсчээ.


Агаарын тээврийн ачаа эргэлт 29.0 сая тн.км болж 2019 онтой харьцуулахад 2.1 дахин, өмнөх оноос 19.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Шилжүүлсэн сая тн.км	2022 он	2023 он	2024 он	Өсөлт
Автотээвэр	6,033.8	11,419.1	13,717.0	20.1%
Төмөр зам	15,611.7	19,667.0	22,003.7	11.9%
Агаарын тээвэр	198.5	377.6	518.4	37.3%

Шилжүүлсэн тн.км-ээр тооцсон тээврийн үзүүлэлт мөн бүх салбарт өсөлттэй байлаа. Өмнөх онтой харьцуулахад хамгийн өндөр дүнгээр буюу 2,336.7 сая тн.км-ээр өссөн нь төмөр замын тээвэр байсан бол өсөлтийн хамгийн өндөр хувийг агаарын тээврийн салбар үзүүлжээ.

Ачаа тээврийн хэмжээ өсөхөд уул уурхайн олборлолт 50%-аар, нийт экспорт 21%-аар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар



2024 онд нийт 131.1 сая тонн ачаа тээвэрлэснээс 118.6 сая тонн буюу 90.5%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 5.1 сая тонн буюу 3.9%-ийг барилгын салбарын бүтээгдэхүүн, 1.5 сая тонн буюу 1.1%-ийг хүнс хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 5.9 сая тонн буюу 4.5%-ийг бусад салбарын ачаа эзэлж байна.

Эдийн засгийн салбарын ачаа тээврийн өөрчлөлт нь тухайн салбарын өсөлт, бууралттай шууд хамааралтай байна.

Уул уурхайн олборлолт болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэж, 2024 онд автотээврээр тээвэрлэсэн ачааны 96.2%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 80.0% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.


Барилгын салбарын түүхий эд, бүтээгдэхүүний тээврийн хэмжээ 2024 онд 5.1 сая тонн болж өмнөх оноос 15.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөө, аж ахуйн салбарын өсөлт саарсан нь уг салбарын бүтээгдэхүүний тээврийн хэмжээнд нөлөөлж 2022 онд 2.6 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэж байсан бол 2023 онд 1.4 сая тонн болж 44.4%-аар буураад байсан бол 2024 онд 1.5 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэж өмнөх оноос 1.8%-аар өссөн байна. Харин бусад салбарын бүтээгдэхүүний ачаа тээврийн хэмжээ өмнөх оноос 21.5%-аар буурсан байна.


Экспортын тээврийн 99.2%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 88.1% буюу 81.9 сая тонн ачааг автотээврээр, 11.9% буюу 11.0 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийг бүтээгдэхүүнээр авч үзвэл, 82.2 сая тонн буюу 88.5%-ийг нүүрс, 7.3 сая тонн буюу 7.8%-ийг төмрийн хүдэр, 1.6 сая тонн буюу 1.7%-ийг зэсийн баяжмал, 1.3 сая тонн буюу 1.4%-ийг жонш, 483.9 мянган тонн буюу 0.5%-ийг газрын тос, 51.8 мянган тонн буюу 0.1%-ийг цайрын баяжмал тус тус эзэлж байна.

Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт



Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр




2024 онд ачаа тээврийн хэмжээ тээвэрлэлтийн бүх төрлөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2023 он	2024 он
Нийт тээсэн ачаа, сая тонн		107,377.6	131,075.0
Транзит	Төмөр зам	5,094.4	5,299.2
	Төмөр зам	11,128.9	11,610.1
	Автотээвэр	68,245.0	82,076.6
Нийт		79,373.8	93,686.7
Импорт	Төмөр зам	3,629.5	3,794.2
	Автотээвэр	3,010.0	3,088.9
	Нийт	6,639.5	6,883.1
Дотоодод	Төмөр зам	16,261.3	25,195.5
	Агаар	8.57	10.4
	Нийт	16,269.9	25,205.9

Бүх төрлийн тээврээр тээсэн экспортын ачаа 93.7 сая тонн болж өмнөх оноос 18%-аар, дотоодын ачаа 25.2 сая тонн

болж өмнөх оноос 54.9%, импортын ачаа 6.9 сая тонн болж өмнөх оноос 3.7%-аар, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.3 сая тонн болж өмнөх оноос 4.0%-аар тус тус өсжээ.

Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин




Экспортын ачаа 18%-аар өссөн хэдий ч 2023 онд 73.9%-ийг эзэлж байсан экспортын тээвэр 2024 онд 71.5% болж, импортын ачаа өмнөх оноос 3.7%-аар өссөн хэдий ч нийт тээврийн хэмжээнд эзлэх хувь 6.2%-аас 5.3% болж өөрчлөгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн эзлэх хувь 4.0% байна.

Дотоодын ачаа тээвэр 2023 онд 16.3 сая тонн буюу нийт ачаа тээврийн 15.1%-ийг эзэлж байсан бол 2024 онд 25.2 сая тонн болж өссөн нь 19.2%-ийг эзэлжээ. Үүнээс харахад дотоодын ачаа тээврийн хэмжээ өсжээ.

Зураг 9 Тээвэрлэлтийн төрөл, салбараар



Улс хоорондын ачаа тээвэр буюу экспорт, импортын ачаа тээврийг төмөр зам, автотээвэрээр гүйцэтгэж байгаа бол транзит тээвэр болон дотоодын тээвэрт төмөр зам голлох үүрэг гүйцэтгэж байна.

Монгол Улс өнөөдөр хоёр хөрштэйгөө төмөр замын 3 боомт, авто замын 13 боомтоор экспорт, импортын тээвэр хийж байна.

Төмөр замын боомтоор хоногт дунджаар 15.6 галт тэрэг солилцож, солилцсон вагоны тоо 26.3 хувиар нэмэгдсэн нь төмөр замаар тээх экспортын ачаа нэмэгдэхэд нөлөөлжээ.

2024 онд автотээвэрээр экспортын ачааны 87.6%, импортын ачааны 44.9%-ийг тээсэн бол төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 55.1%, экспортын ачааны 12.4%-ийг тээвэрлэжээ.

2023 онд улс хоорондын ачаа тээвэр 86.0 сая тонн болж нийт ачаа тээврийн 80.1%-ийг эзэлж байсан бол 2024 онд 100.6 сая тонн болж нийт ачаа тээврийн 76.7%-ийг эзэлж байна.

Зураг 10 Улс хоорондын ачаа тээвэр



2024 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.5% нь БНХАУ-тай хиллэж буй 10 боомтоор, 3.5% нь ОХУ-тай хиллэж буй 3 боомтоор орж, гарсан байна.

Үүнээс хамгийн их буюу 38.9% Гашуунсухайт, 24.6% нь Шивээхүрэн, 15.2% нь Замын-Үүд, 8.6% нь Ханги боомтоор орж, гарсан бол Алтанбулаг боомтоор 3.4 сая тонн ачаа буюу 3.4% нь орж, гарчээ.

БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 96.3% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 92.8% нь импортын ачаа байна.

Монгол Улсын экспортын ачааны 99.7% БНХАУ руу гарсан бол импортын ачааны 52.2% нь БНХАУ-аас, 47.8% ОХУ-аас орж иржээ.

Зураг 11 Ачаа гаргалт (экспорт)



2024 онд Гашуунсухайт боомтоор хамгийн их буюу 38.7 сая тонн ачаа гарсан нь нийт ачаа гаргалтын 41.3%-ийг эзэлж байгаа бол Шивээхүрэн боомтоор 26.2%, Замын-Үүд боомтоор 13.1% нь гарчээ.

2024 онд нийт импортын ачааны 45.4% нь Алтанбулаг боомтоор, 44.2% нь Замын-Үүд боомтоор, 5.1% нь Гашуунсухайт боомтоор, 1.6% нь Цагааннуур боомтоор орж ирсэн бол 3.7% нь бусад боомтоор орж иржээ.

Зураг 12 Ачаа оруулалт (импорт)




Замын-Үүд боомтоор БНХАУ-аас орж ирж буй импортын ачааны 84.6% буюу 3.0 сая тонн ачаа, Гашуунсухайтын боомтоор 9.7% буюу 349.7 мянган тонн ачаа орж ирсэн бол Шивээхүрэн боомтоор 131.2 мянган тонн ачаа буюу 3.7% нь орж иржээ.

ОХУ-аас орж ирж буй импортын ачааны хувьд 95.0% буюу 3.1 сая тонн ачаа Алтанбулаг боомтоор орж ирсэн бол Цагааннуур боомтоор 3.5%, Боршоо боомтоор 1.5% нь орж ирсэн байна.

2024 онд төмөр замаар тээсэн дотоодын ачаа өмнөх оноос 54.9%-аар өссөн нь хамгийн өндөр өсөлт байв. Үүнд дотоодын төмөр замын байгууллагуудын ачаа тээвэрлэлт өссөн нь голлон нөлөөлжээ.


Зураг 13 Төмөр замын дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин



Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэсэн нь дотоодын ачааны өсөлтөд нөлөөлжээ.

2024 онд "Улаанбаатар төмөр зам" ХНН дотоодын ачааны 12.5 сая тонн буюу 51%-ийг, бусад төмөр замын байгууллагууд дотоодын ачааны 49%-ийг тээвэрлэжээ.

2024 ОНД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРЭЭР 149.4 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.




Зорчигч тээвэр

Бүх төрлийн тээврээр 2024 онд нийт 149.4 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 2.0%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 142.8 сая байна.

Мөн агаарын тээврээр 2.2 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 25.2%, автотээврээр 145.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 1.8%, усан замаар 94.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 45.7%-аар тус тус өссөн бол төмөр замаар 2.0 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 7.7%-аар буурсан байна.

Тээврийн төрөл	2021	2022	2023	2024	2024/2023
Нийт зорчигчдын тоо, сая хүн	107.1	146.3	146.5	149.4	2.0%
Автотээвэр	106.5	143.0	142.6	145.1	1.8%
Төмөр замын тээвэр	0.4	2.4	2.1	2.0	-7.7%
Агаарын тээвэр	0.2	0.9	1.7	2.2	25.2%
Усан замын тээвэр	0.02	0.04	0.06	0.09	45.7%
Зорчигч эргэлт, сая хүн/км	1,563.44	4,444.8	6,492.7	7,886.2	21.5%
Автотээвэр	1,023.01	1,914.9	1,813.2	2,204.5	21.6%
Төмөр замын тээвэр	90.66	701.5	797.5	786.1	-1.4%
Агаарын тээвэр	449.37	1,828.4	3,880.8	4,894.0	26.1%
Усан замын тээвэр	0.4	0.9	1.2	1.6	31.7%

Зураг 14 Зорчигч тээвэр




2023 онд автотээврийн зорчигчийн 98.4%-ийг нийслэлийн тээврийн зорчигч эзэлж байсан бол 2024 онд мөн 98.4%-ийг эзэлж байгаа нь автотээврээр зорчсон зорчигчийн тоо өссөн ба нийслэлийн тээврийн зорчигч мөн адил өссөнийг харуулж байна.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2023 он	2024 он
Нийт зорчигч		146,490.8	149,355.9
Олон улсад зорчигч	Автотээвэр	850.2	769.0
	Төмөр зам	23.7	41.2
	Агаарын тээвэр	1,312.2	1,746.9
	Нийт	2,186.0	2,557.1
Орон нутагт зорчигч	Автотээвэр	1,417.1	1,570.1
	Төмөр зам	2,118.1	1,935.3
	Агаарын тээвэр	419.1	420.4
	Усан зам	64.7	94.2
	Нийт	4,019.0	4,020.0
Нийслэлд зорчигч	Автотээвэр	141,643.7	142,778.8

Цар тахлаас үүдэлтэй огцом буурсан зорчигч тээврийн хэмжээ сүүлийн жилүүдэд өссөөр байна. 2023 онд бүх төрлийн тээврээр улс хооронд болон хот хооронд зорчсон зорчигчдын тоо 6.2 сая байсан бол 2024 онд 6.6 сая болж өмнөх оноос 6.0%-аар өслөө.


Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт



Улс хооронд болон орон нутаг агаарын тээврээр 2.2 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 25.2%, усан замаар 94.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 45.7%, автотээврээр 2.3 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 2.0 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 7.7%-аар буурсан байна.


Тээврийн төрлөөр авч үзвэл 2024 онд улс хооронд болон хот хооронд зорчигчдын 35.6% нь автотээврээр, 30.1% нь төмөр замаар, 33.9% нь агаарын тээврээр, 1.4% нь усан замаар зорчсон байна.

Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь



2024 онд олон улсад бүх төрлийн тээврийн хэрэгслээр нийт 2.6 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 17.0%-аар өслөө.

Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр



Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 1.7 сая болж өмнөх оноос 33.1%-аар өссөн нь нийт олон улсад зорчигчдын 68.3%-ийг эзэлж байна.


Харин автотээврийн олон улсын зорчигчдын тоо 2024 онд 769.0 мянга болж өмнөх оноос 9.6%-аар буурсан байна.

2023 оны 8 дугаар сараас төмөр замын олон улсын зорчигч тээврийг эхлүүлсэн бөгөөд 23.7 мянган зорчигч тээвэрлэж байсан бол 2024 онд 41.2 мянган зорчигч тээвэрлэж өмнөх жилээс 73.8%-аар өсжээ.

Автотээвэр болон төмөр замаар олон улсад зорчсон зорчигчдын 42.7% нь Замын-Үүдийн боомтоор нэвтэрсэн бол 4.7% нь Алтанбулагийн боомтоор, 52.6% нь бусад авто замын боомтуудаар нэвтэрсэн байна.

Бүх төрлийн тээврээр орон нутагт зорчигчдын тоо 2024 онд 4.0 сая болж өмнөх оноос 0.03%-аар өссөн байна.

Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр



2024 онд орон нутагт зорчигчдын хамгийн их буюу 48%-ийг төмөр замын зорчигчид эзэлж байгаа бөгөөд 2.0 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 7.7%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Төмөр замаар орон нутагт зорчигчдын тоо буурахад төмөр замын зорчигч тээврийн тарифын өсөлт, зорчигч тээврийн вагоны насжилт болон авто замын нөхцөл байдал сайжирч, автотээврээр зорчигчдын тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2024 онд автотээврээр орон нутагт зорчигчдын тоо өмнөх оноос 10.8%-аар өсч 1.6 сая болсон нь орон нутагт зорчигчдын 39.1%-ийг эзэлж байна.

Зам, тээврийн яамнаас 2023 оноос орон нутгийн зорчигч тээврийн чиглэлд агаарын тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн нислэгийг сэргээх бодлогыг баримтлан ажиллаж байна. Бодлогын арга хэмжээний үр дүнд 2024 онд агаарын тээврээр орон нутагт зорчигчдын тоо 420.4 мянга болсон байна.

2024 онд нийт зорчигч эргэлт 7,886.2 сая хүн.км болж өмнөх оноос 21.5%-аар өсжээ. Үүнээс агаарын тээврийн зорчигч эргэлт хамгийн өндөр хувиар буюу 26.1%-аар нэмэгдэж, 4,894.0 сая хүн.км болжээ. Төмөр замын тээврийн зорчигч эргэлт 1.4%-аар буурсан бол автотээврийн зорчигч эргэлт 21.5%-аар өссөн байна.

Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км



БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР

МОНГОЛ УЛС УЛСЫН ЧАНАРТАЙ
7,887.8 км, НИЙТ 10,830.5 км ХАТУУ
ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМТАЙ БАЙНА.

Зураг 20 Улсын чанартай авто зам



Үндэсний авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,960.1 км авто зам, орон нутгийн чанартай 95,990.6 км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам байна.


Улсын чанартай 14,960.1 км авто замыг төрлөөр нь ангилбал, хатуу хучилттай авто зам 7,887.8 км, ердийн хөрсөн зам 5,711.9 км, сайжруулсан хөрсөн зам 310.1 км, хайрган хучилттай зам 1,050.3 км байна. Хатуу хучилттай авто замаас 7,863.0 км нь асфальт бетон, 24.8 км нь цемент бетон авто зам байна.

Зураг 21 Орон нутгийн чанартай авто зам



Үндэсний авто замын сүлжээний орон нутгийн чанартай 95,990.6 км авто замыг төрлөөр нь ангилбал, ердийн хөрсөн 93,365.5 км, сайжруулсан хөрсөн 393 км, хайрган хучилттай 255.43 км, хатуу хучилттай 1,941.8 км авто зам байна. Үүнээс хатуу хучилттай замыг 1,941.8 км асфальт бетон, 34.9 км цемент бетон авто зам бүрдүүлж байна.

Зураг 22 Тусгай зориулалтын авто зам




Тусгай зориулалтын хатуу хучилттай 966.0 км авто зам байгаагаас 922.8 км нь асфальт бетон, 43.2 км цемент бетон авто зам байна. Тусгай зориулалтын авто замын урт өмнөх оноос 1.1%-аар нэмэгдсэн байна.


Зураг 23 Улсын чанартай авто замын гүүр

2024 онд улсын хэмжээнд нийт 208.9 урт метр гүүр ашиглалтад орсон. Үүнээс улсын чанартай авто зам дагуу 35.0 урт метр, орон нутгийн чанартай авто замд 173.9 урт метр гүүрийг ашиглалтад орууллаа.

Улсын чанартай авто зам дагуу нийт 389 гүүр байгаа нь нийлээд 17,293.1 урт метр байна. Үүнээс нийтдээ 15,959.4 урт метр 333 төмөр бетон гүүр, 284 урт метр 1 ган гүүр, 1049.7 урт метр 55 модон гүүр гүүр бүртгэлтэй байна.



Зураг 24 Улсын чанартай авто замын сүлжээ



2024 онд нийт 567.1 км хатуу хучилттай авто замыг шинээр ашиглалтад орууллаа. Үүнээс улсын чанартай 352.2 км хатуу хучилттай авто зам шинээр ашиглалтад оруулсан байна.

Ингэснээр олон улс, улсын чанартай 7,887.8 км, орон нутгийн чанартай 1,976.7 км, тусгай зориулалтын 966.0 км, нийт 10,830.5 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг замын төрлөөр авч үзвэл 52.7% буюу 7,887.8 км хатуу хучилттай, 7.0% буюу 1050.3 км хайрган хучилттай, 2.1% буюу 310.1 км нь сайжруулсан хөрсөн зам байгаа бол 38.2% буюу 5,711.9 км нь ердийн хөрсөн зам байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Азийн авто замын сүлжээний босоо тэнхлэгийн АН-3 чиглэлийн, АН-4 болон хэвтээ тэнхлэгийн АН-32 чиглэл дайран өнгөрдөг.

Орос-Хятадыг хатуу хучилттай авто замаар холбосон Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн 1,002.9 км авто замын сүлжээний Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж, хөдөлгөөнийг бүрэн нээлээ.

Авто замын сүлжээг өргөжүүлснээр 2024 оны байдлаар 21 аймаг, 107 сум хатуу хучилттай авто замтай болоод байна.

БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР


АВТОТЭЭВРЭЭР УЛС, ХОТ ХООРОНД БОЛОН ХОТ ДОТОР НИЙТ 145.1 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

Зорчигч тээвэр

2024 онд автотээврээр нийт 145.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 1.8%-аар, зорчигч эргэлт 2,204.5 сая хүн.км болж 21.6%-аар тус тус өссөн байна. Үүнд нийслэлийн нийтийн тээврээр 142.8 сая зорчигч зорчиж өмнөх оноос 1.78%-аар өссөн нь голлон нөлөөлжээ.


Хот хооронд буюу орон нутагт 1.6 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.8%-аар, зорчигч эргэлт 12.9%-аар тус тус өссөн бол олон улсад 769.0 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 9.5%-аар буурсан байна.

Зураг 25 Автотээврийн зорчигч, сая хүн



Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2024 он	2024/2023
Нийт зорчигч тээвэр	мян.хүн	143,000.0	142,553.0	145,117.9	1.8%
Олон улсад зорчигчид	мян.хүн	34.7	850.2	769.0	-9.5%
Хот хоорондын зорчигч	мян.хүн	1,321.6	1,417.1	1,570.1	10.8%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	мян.хүн	141,643.7	140,285.7	142,778.8	1.78%
Зорчигч эргэлт	сая хүн.км	1,914.9	1,813.2	2,204.5	21.6%
Хот хооронд зорчигч эргэлт	сая хүн.км	847.9	941.1	1,062.3	12.9%
Хот доторх зорчигч эргэлт	сая хүн.км	1,116.8	872.2	1,142.2	31.0%

Зураг 26 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр




Зураг 27 Автотээврийн зорчигч эргэлт



Нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо өссөн нь автотээврийн зорчигч эргэлт өсөхөд голлон нөлөөлжээ. Автотээврийн зорчигч эргэлт нийт зорчигч эргэлтийн 27.9%-ийг эзэлж байна.

АВТО ЗАМЫН ХИЛИЙН БООМТООР
АВТОТЭЭВРЭЭР 85.2 САЯ ТОНН АЧАА
ТЭЭВЭРЛЭЖ 19.5%-ААР ӨСЛӨӨ.



Ачаа тээвэр


2024 онд авто замын боомтуудаар нийт 85.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь түүхэн үзүүлэлт боллоо.

2024 оны автотээврийн ачаа өмнөх оноос 19.5%-аар өссөн бөгөөд үүнээс нийт 82.1 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 20.3%, 3.1 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.6%-аар тус тус өссөн байна.

Автотээврийн ачаа тээвэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2024 он	2024/2023
Нийт тээсэн ачаа	мян.тонн	33,075.6	71,254.9	85,165.5	19.5%
Ачаа оруулалт - импорт	мян.тонн	1,070.7	3,009.9	3,088.9	2.6%
БНХАУ-аас	мян.тонн	758.1	2,661.1	2,714.3	2.0%
ОХУ-аас	мян.тонн	312.6	348.9	374.6	7.4%
Ачаа гаргалт - экспорт	мян.тонн	32,004.9	68,244.9	82,076.6	20.3%
БНХАУ руу	мян.тонн	31,995.4	68,100.3	82,020.7	20.4%
ОХУ руу	мян.тонн	9.5	144.6	55.8	-61.4%
Ачаа эргэлт	сая тн.км	2,591.9	10,619.1	12,746.1	20.0%

2024 онд тээсэн нийт экспортын ачааны 87.6%-ийг автотээвэрээр тээжээ.

Зураг 28 Автотээврийн экспортын ачаа




Автотээврийн экспортын ачааны 99.9%-ийг БНХАУ руу тээвэрлэсэн бол, 0.1%-ийг ОХУ руу тээвэрлэжээ.

2024 онд авто замын 12 боомтоор нийт 82.1 сая ачаа экспортолсон нь өмнөх оноос 20.3%-аар өссөн үзүүлэлт юм. Үүнээс Гашуунсухайт боомтоор хамгийн их 47.2% буюу 38.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 5.4%, Шивээхүрэн боомтоор 29.9% буюу 24.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 28.5%, Ханги боомтоор 10.6% буюу 8.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 73.4%, Бичигт боомтоор 5.2% буюу 4.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 54.3%, Булган боомтоор 4.3% буюу 3.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 30.3%-аар, Замын-Үүд боомтоор автотээврийн экспортын ачааны 1.1% буюу 864 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 24.1%-аар тус тус өсжээ.

ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 55.8 мянган тонн ачаа экспортолсон нь 3%-аар өссөн боловч Цагааннуур боомтоор экспортод ачаа тээвэрлээгүй байна.

Зураг 29 Экспортын ачаа, эзлэх хувь



2024 онд автотээврээр 79.6 сая тонн нүүрс (+20.3), 982.5 мянган тонн зэсийн баяжмал (+56.5%), 456.8 мянган тонн газрын тос (-12.9%), 135.2 мянган тонн бусад ачаа (-81.1%) тээвэрлэсэн бол 753.6 төмрийн хүдэр тээвэрлэсэн нь 3.6 дахин, 131.9 мянган тонн жонш 16 дахин тус тус өслөө. Мөн 5.5 мянган цайр экспортолсон байна.

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2024 он	2024/2023
Нүүрс	мян.тонн	30,182.0	66,156.6	79,611.1	20.3%
Газрын тос	мян.тонн	346.0	524.6	456.8	-12.9%
Зэсийн баяжмал	мян.тонн	501.3	627.8	982.5	56.5%
Төмрийн хүдэр	мян.тонн	912.2	211.9	753.6	255.5%
Жонш	мян.тонн	6.1	8.2	131.9	1499.9%
Цайр	мян.тонн	0.0	0.0	5.5	-
Бусад	мян.тонн	57.4	715.7	135.2	-81.1%

Зураг 30 Автотээврийн импортын ачаа




Автотээврээр 2024 онд импортын ачааны 44.9%-ийг буюу нийт 3.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.6%-аар өссөн үзүүлэлт байна. Импортын тээврийн 87.9%-ийг БНХАУ-тай, 12.1%-ийг ОХУ-тай хиллэдэг боомтуудаар тээвэрлэжээ.

Үүнээс Замын-Үүд боомтоор хамгийн их буюу 2.2 сая тонн ачаа импортолсон нь 69.9%-ийг эзэлж байгаа бол Гашуунсухайт боомтоор 11.3% буюу 349.7 мянган тонн, Алтанбулаг боомтоор 6.8% буюу 211.5 мянган тонн ачаа бусад боомтуудаар нийлээд 11.9%-ийг эзлэх ачаа оруулжээ.

Ачаа тээвэр боомтуудаар	2023 он		2024 он	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
Нийт ачаа, мян.тонн	3,010.0	68,245.0	3,088.9	82,076.6
Алтанбулаг	181.9	54.2	211.5	55.8
Бичигт	-	2,766.1	8.7	4,267.4
Баянхошуу	12.4	528.2	10.5	456.8
Бургастай	0.02	206.3	0.3	631.4
Булган	73.5	2,714.1	0.0	3,536.7
Боршоо	33.4	-	49.6	0.0
Гашуунсухайт	851.9	36,750.5	349.7	38,732.7
Замын-Үүд	1,707.1	696.2	2,159.8	864.0
Цагаан нуур	133.6	90.4	133.5	0.0
Ханги	1.4	5,006.1	18.4	8,678.9
Хавирга	14.7	320.2	35.7	290.8
Шивээ хүрэн	-	19,107.1	131.2	24,562.0
Сүмбэр	-	5.5	-	-
БНХАУ	2,661.1	68,100.3	2,714.3	82,020.7
ОХУ	348.9	144.6	374.6	55.8
Нийт	71,254.9		85,165.5	

Зураг 31 Боомтоор нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгсэл, эзлэх хувь



Автозамын боомтуудаар 2024 онд нийт 943,409 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бол үүнээс 148,588 ачаатай тээврийн хэрэгсэл хилээр орсон, 794,821 ачаатай тээврийн хэрэгсэл хилээр гарсан байна.


БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 869,631 болж өмнөх оноос 8.2%-аар нэмэгдсэн нь нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн 92.2%-ийг эзэлж байна. 2022 онд энэ үзүүлэлт 75.2%, 2023 онд 87.1%-ийг эзэлж байжээ.

ОХУ-тай хиллэдэг боомтуудаар 73.8 мянган тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 38.1%-аар буурсан ба хил нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн 7.8%-ийг эзэлж байна.

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2022 он	2023 он	2024 он	2024/2023
Орсон тээврийн хэрэгсэл	94,443.0	223,224.0	148,588.0	-33.4%
БНХАУ-аас	73,344.0	202,331.0	112,872.0	-44.2%
Бичигт	474.0	-	300.0	-
Баянхошуу	673.0	476.0	422.0	-11.3%
Булган	3,654.0	624.0	0.0	-100.0%
Бургастай	3.0	3.0	9.0	200.0%
Гашуунсухайт	6,579.0	4,915.0	8,743.0	77.9%
Шивээхүрэн	35,130.0	131,500.0	3,281.0	-97.5%
Замын-Үүд	25,860.0	64,209.0	98,555.0	53.5%
Ханги	971.0	168.0	734.0	336.9%
Хавирга	-	436.0	828.0	89.9%
ОХУ-аас	21,099.0	20,893.0	35,716.0	70.9%
Алтанбулаг	11,896.0	12,686.0	13,484.0	6.3%
Боршоо	1,378.0	1,461.0	2,150.0	47.2%
Цагааннуур	7,825.0	6,746.0	20,082.0	197.7%
Гарсан тээврийн хэрэгсэл	432,490.0	700,290.0	794,821.0	13.5%
БНХАУ-руу	322,741.0	601,983.0	756,759.0	25.7%
Бичигт	1,788.0	38,159.0	47,894.0	25.5%
Баянхошуу	9,608.0	16,232.0	13,784.0	-15.1%
Булган	30,360.0	34,526.0	48,696.0	41.0%
Бургастай	15,494.0	4,807.0	14,765.0	207.2%
Гашуунсухайт	157,762.0	266,259.0	331,317.0	24.4%
Шивээхүрэн	35,836.0	166,263.0	198,651.0	19.5%
Замын-Үүд	30,364.0	6,829.0	13,695.0	100.5%
Ханги	41,529.0	65,713.0	85,714.0	30.4%
Хавирга	-	3,069.0	2,243.0	-26.9%
Сүмбэр	-	126.0	0.0	-100.0%
ОХУ-руу	109,749.0	98,307.0	38,062.0	-61.3%
Алтанбулаг	100,382.0	84,151.0	11,253.0	-86.6%
Боршоо	1,345.0	1,387.0	2,158.0	55.6%
Цагааннуур	8,022.0	12,769.0	24,651.0	93.1%

МОНГОЛ УЛСАД 1 338 956 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 32 Тээврийн хэрэгслийн ангилал




Тээврийн хэрэгслийг хүрдний байрлалаар авч үзвэл баруун буюу буруу жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 65.9%, зүүн буюу зөв жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл нь 34.1%-ийг эзэлж байна.

2024 онд баруун хүрдтэй тээврийн хэрэгсэл өмнөх оноос 14.8%-аар, зүүн хүрдтэй тээврийн хэрэгсэл 7.7%-аар нэмэгджээ.

Монгол Улсад 2024 оны жилийн эцсийн байдлаар 1,338,956 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 146,436 тээврийн хэрэгслээр буюу 12.3%-аар өссөн байна.

